

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН**  
**АГААР БОХИРДУУЛАГЧ ЭХ ҮҮСВЭРИЙН**  
**2021 ОНЫ ТАЙЛАН**



**ӨЛГИЙ ХОТ**

**2021**





**НЭГ.ЕРӨНХИЙ ТОЙМ**

Зорилго:**Баян-Өлгий** аймгийн хэмжээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн төрөл, тоо хэмжээг шинэчлэн жил бүр тогтоож бүртгэлд хамруулах, тэдгээрийн талаар мэдээллийн нэгдсэн санг бий болгоход оршино.

Ерөнхий зохион байгуулалтын ажил: Монгол улсын “Агаарын тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2018 оны А-479 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ыг үндэслэн, Аймгийн засаг даргын Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах тухай 2021 оны А/973 тоот захирамжын дагуу ажлын хэсэг байгуулж, аймгийн Засаг даргын тамгын газрын

даргын 2022 оны “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого зохион байгуулах тухай” албан тоотын дагуу уг ажлыг зохион байгуулав.

Сумдууд дотроо ажлын хэсэг байгуулж ажиллав. Манай нэгдсэн групаар Алтай, Өлгий, Толбо, Улаанхус, Цэнгэл сумдууд засаг даргын захирамжуудаа явуулсан



Баян- Өлгий аймгийн агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллогыг сумдын Засаг даргын тамгын газар болон УЦОШТөв, Мэргэжлийн хяналтын газар, “Эрчимбаян-Өлгий” ХК-ний инженер, байцаагч нартай хамтран зохион байгуулан, тооллогын мэдээллийг нэгтгэн боловсруулан тайланг хүргүүлж байна.

2021 оны агаар бохирдуулах эх үүсвэрийн нэгдсэн тооллогыг Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2018 оны А-479 тоот тушаалын 1-5 дугаар маягтуудад, агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах гарын авлагын зааврын дагуу, хоёрдугаар хавсралтын дагуу, тэмдэглэж 6-8 -р маягтуудад нэгдсэн дүнг гаргасан. Мөн барилгын эзэлхүүнээс хамааруулан зуухны нэрлэсэн хүчин чадалыг

ойролцоогоор тодорхойлох аргыг, “Агаар бохирдуулах бодисын хаягдлын тооллого хийх аргачлал”-номыг ашигласан.

АБЭҮ-ийн онлайн сургалтууд:

2020 онд “Орчны бохирдлыг тоолох” шинэ программ гарсантай холбоотой онлайн сургалтанд манай аймгийн 12 сумын бүх байгаль хамгаалагч, байцаагч, багийн дарга нарыг хамруулж шинээр ажилд томилогдсан 5 байгаль хамгаалагч, байцаагч нарын гар утасанд суулгаж өгсөн.

Агаарын бохирдолын эх үүсвэрийн тооллого хийх журмын дагуу тоо бүртгэлд агаарын бохирдлын доорхи эх үүсвэрүүдийг хамруулан тоолсон байна. Эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг эхүүсвэрээр нь дараах байдлаар ангилж бүртгэнэ. Үүнд:

2.1.1 агаарын бохирдлын суурин эх үүсвэр

2.1.2 агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэр

Агаарын бохирдлын суурин эх үүсвэр:

- ✓ 3-15 кВт хүртэлх хүчин чадалтай зуух /гэр, байшин, төвлөрсөн халаалтанд холбогдоогүй жижиг аж ахуйн нэгж, үйлчилгээний газрууд /
- ✓ 15-100 кВт хүртэлх хүчин чадалтай усан халаалтын зуух
- ✓ 100-4200 кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон ус халаах зуух
- ✓ 4200 гаас дээш хүчин чадалтай зуух

Агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэр:

- ✓ Автотээврийн хэрэгсэл

Баян-Өлгий аймгийн 2021 оны нэгдсэн тоо, бүртгэлийн дүнгээр агаар бохирдуулагч суурин эх үүсвэр нийт **10273** бүртэгдсэн. Үүнд: Галлагаатай өрх, төвлөрсөн халаалтад холбогдоогүй 3-15кВт хүртэл хүчин чадалтай зуух ашигладаг **10100** айл өрх, аж ахуй нэгж, 15-100кВт хүртэл хүчин чадалтай зуух ашигладаг **132** аж ахуй нэгж, 100-4200 кВт-с дээш хүчин чадалтай зуух **38**, 4200-аас дээш хүчин чадалтай **3** зуух тоологдсон ба аймгийн хэмжээнд нийт **137387,2 тн нүүрс, 27624,5 тн мод**, байна. Хөдөлгөөнт эх үүсвэр **15591** тоологдсон.

2021 оны Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлээр

Аймгийн төвийн 13 баг, Сумын 12

- |             |              |          |
|-------------|--------------|----------|
| • Алтай     | • Бугат      | • Толбо  |
| • Алтанцөгц | • Ногооннуур | • Цэнгэл |
| • Баяннуур  | • Сагсай     |          |
| • Булган    | • Дэлүүн     |          |
| • Буянт     | • Улаанхус   |          |

## ХОЁР. СУУРИН ЭХ ҮҮСВЭРИЙН ТОО БҮРТГЭЛ

2.1. Ердийн галлагаатай 3-15 кВт хүртэл хүчин чадалтай зуухны тооллогын дүн

2021 оны Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоо бүртгэлээр 12 сумын хэмжээнд

Ердийн галлагаатай 3-15 кВт хүртэл хүчин чадалтай айл өрхийн зуух нийт 80919,5 тн нүүрс, 27286.5 мод түлшиндээ хэрэглэж байна. Үүнд: 10100 байшин тоологдсон.

2020 оны агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн дүнтэй харьцуулж үзвэл.Ердийн галлагаатай 3 кВт болон 15 -ээс дээш хүчин чадалтай айл өрхийн зуух 540 зуух болон 5.3 %- иар их ба нүүрс, мод өмнөх оноос их түлсэн байна. Энэ нь шилжих хөдөлгөөнтэй холбоотой байна.

### **2021 оны Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоо бүртгэлээр аймгийн төвийн хэмжээнд**


Ердийн галлагаатай 3-15 кВт хүртэл хүчин чадалтай айл өрхийн зуух нийт 53955 тн нүүрс, 16186 м3 мод түлшиндээ хэрэглэж байна. Үүнд: 5866 байшин, 40 гэр тоологдсон.

2020 оны агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн дүнтэй харьцуулж үзвэл. Ердийн галлагаатай 3-15 кВт айл өрх 201 зуух буюу 3,4%- иар их, өмнөх оноос 26%-иар их нүүрс хэрэглэсэн байна.

### **Хүснэгт 1. Ердийн галлагаатай зуухны тоо**

№	Сумд	Айл өрхийн зуух				
		Гэр	Байшин	Түлшний хэмжээ		
				Нүүрс, тн	бусад	Мод
1	Өлгий	40	5866	53955		16186
2	Алтай		299	1937		19
3	Алтанцөгц		175	1143		844
4	Бугат		315	3022		2434
5	Буянт		208	2364		1204
6	Баяннуур		378	2112,5		770
7	Цэнгэл		645	3771		1795
8	Улаанхус		272	1665		642,5
9	Сагсай		309	2293		1140
10	Булган		350	1454		739
11	Ногооннуур		575	3081		664
12	Толбо		258	2285		102
13	Дэлүүн		410	1837		747
<b>Аймгийн хэмжээнд</b>			<b>10100</b>	<b>80919,5</b>		

Зурмаг-1 /3-15 хүртэл хүчин чадалтай зуух сүүлийн 5 жилээр/



Энэ зурмагаас ажиглахад 2021 онд айл өрхийн түлшний хэмжээ болон тоон үзүүлэлт өссөн байна.

## 2.2 Усан халаалтын 15-100 кВт хүчин чадалтай зуухны тооллогын дүн

Аймгийн хэмжээнд 88 аж ахуй нэгж байгууллага 15-100кВт-ын хүчин чадалтай зуух ашиглаж нийт 1423 тн нүүрс зарцуулж дулаан үйлдвэрлэсэн байна.

Ахуйн хэрэглээнд ашиглагдаж байгаа уурын болон усан халаалтын зуух, технологийн зориулалттай уур үйлдвэрлэдэг зуух, төвлөрсөн болон нэгдсэн дулаан хангамжийн усан халаалтын зуух, барилгын болон томоохон үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглагдаж байгаа зуухнууд орно. 2020 онд тоологдсон зуухнуудын 6 н энэ жил төвлөрсөн халаалтанд холбогдсон.



**Зурмаг 2-д** 15-100 квт хүртэл хүчин чадалтай зуух өмнөх жилээс 44 зуух их тоологдсон байна.

## 2.3 100-4200 кВт-с дээш хүчин чадалтай зуухны тооллогын дүн

Аймгийн хэмжээнд 38 аж ахуй нэгж байгууллага 100-4200 квт хүртэл хүчин чадалтай зуух, 9 сум Төвлөрсөн халаалтын байгууламжтай нийт 16808 тн нүүрс зарцуулсан

дулаан үйлдвэрлэсэн байна. Баян-Өлгий аймгийн 13 сумын Булган, Ногооннуураас бусад бүх сумдууд нэгдсэн халаалтанд холбогдсон учраас аж ахуйн нэгж байгууллагууд нь төвийн халаалтанд холбогдсон байна. 2020 онтой харьцуулахад 2 зуух бага тоологдсон байна. 2 зуух төвлөрсөн халаалтанд холбогдсон.

#### 2.4 4200 квт –аас дээш хүчин чадалтай зуух

Аймгийн хэмжээнд 4200 квт -аас дээш хүчин чадалтай Баян-Өлгий аймгийн Дулаан станцын гурван зуух тоологдсон байна. 3 зуух нийттэй 34145,7 тн нүүрс түлсэн байна. Өмнөх жилээс нүүрсний хэрэглээ 11,7 %-иар өссөн байна.

### ГУРАВ. ХӨДӨЛГӨӨНТ ЭХ ҮҮСВЭРИЙН ТОО БҮРТГЭЛ


Аймгийн хэмжээнд 2020 онд 12687 тээврийн хэрэгсэл тоологдсон бол энэ жил нийт 15591 тээврийн хэрэгсэл тоологдсон байна. 2904 тээврийн хэрэгсэл илүү тоологдсон байна.



#### 2021 оны Өлгий сумын айл өрхийн агаар бохирдуулах эх үүсвэрийн тооллогын мэдээгээр бохирдлын ялгарал тооцсон үр дүн:

	TSP	Pm10	Pm2,5	CO	NMVOС	NH3
Нийт түлш						

#### 2021 оны Өлгий сумын аж ахуйн байгууллагуудын агаар бохирдуулах эх үүсвэрийн тооллогын мэдээгээр бохирдлын ялгарал тооцсон үр дүн:



	SO <sub>2</sub>	NO <sub>2</sub>	TSP	PM <sub>10</sub>	PM <sub>2.5</sub>	CO
PP						
НОВ						
CFWH						
manufacturing						
<b>Нийт</b>						

Товчилсон үг

SO <sub>2</sub>	Хүхэрлэг хий
NO <sub>x</sub>	Азотын ислүүд
PM <sub>10</sub>	Ширхэглэлийн голч нь 10 микрон буюу түүнээс бага хэмжээтэй тоосонцор
PM <sub>2.5</sub>	Ширхэглэлийн голч нь 2.5 микрон буюу түүнээс бага хэмжээтэй тоосонцор
CO	Нүүрстөрөгчийн дутуу исэл

**2021 онд тоологдсон Шатахуун түгээх станцуудын мэдээлэл**

2021 онд нийт Аймгийн хэмжээнд 68 тоологдсон. Өлгий суманд 28 , бусад суманд 40 тоологдсон байна.

**Дүгнэлт**

Агаар бохирдуулах эх үүсвэрийн тооллогоор айл өрхийн зуухны тоо болон түлэх нүүрс, модны хэмжээ жил ирэх тусам нэмэгдэх хандлагатай байна.

Энэ жилийн судалгаагаар 11 сум төвлөрсөн халаалттай болж 100-4200 дээш хүчин чадалтай зуухнуудын тоо багассан байна.

Хөдөлгөөнт эх үүсвэр 2021 оны 12 сарын 13-ны байдлаар 15591 тоологдсон нь өмнөх оноос 585 ээр нэмэгдсэн байна.

Айл өрхийн зуухны тоологыг өмнөх жил зарим сумдууд 3-15 болон 15-100 хүртэл хүчин чадалтай гээд ялгаж гаргасан юм. Энэ жил программд оруулахад бүгдийг 3-15-д оруулсан болно. Томоохон уурын зуухнууд утаа шүүх шүүлтүүргүй, мөн яндангийн өндөр нь стандарт шаардлага хангаагүй нүүрсний дутуу шаталт их хэмжээгээр агаарт цацагдаж орчны бохирдлыг нэмэгдүүлж байна.

Том оврын уурын зуухнуудын нүүрс, үнсний сав ил задгай байлгаж байгаагийн улмаас салхины нөлөөгөөр их хэмжээний шороо, тоос хөөрч агаарыг бохирдуулж



байна.Эдгээр агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн тоо жил бүр зарим сумуудад нэмэгдэх хандлагатай байна. Өмнөх онуудтой харьцуулсан судалгаанаас харахад түлшний хэрэглээ өссөн байна. Энэ жилийн тооллогын ажлыг сумын хүмүүс өмнөх жилүүдийг бодоход үнэн бодитоор, зарим сумдууд засаг даргын захирамж гаргаж ажилсан болно.

Тооллогын ажлыг 2020 оны 12 сарын 17 ноос 2021 оны 03 сарын 15 ны хооронд явуулав.

### Тооллогын ажлын зураг:

## Өлгий сумын АБЭҮ-ийн аж ахуйн зуухны тооллогын ажлын зурагууд





Өлгий сумын 15-100,100-4200 квтын  
зуухны төрөлүүд





## Зуухны бичиг баримтууд

